



ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА С.ПҮРЭВ ТАНАА

ҮНДСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Баян тойроу 3, Төсвийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.25 № 3/534
Тайлбар - тусгай үйлчилгээний №

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-г заасны дагуу Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн оорчлолт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Татварын ерөнхий газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2016\0325SAG2.Docx



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын
газрын дарга С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Шинжээч: Д.Будмаа
Утас: 261740
chantsaldulamp@audit.gov.mn
budmaad@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний
аудитын газар

Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46
Бага тойруу 6

Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

ХУУДАС

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл.....	3
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин.....	3
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа.....	4
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн.....	5
5. Материаллаг байдал.....	5
6. Дотоод хяналт.....	6
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар.....	7
8. Шилэн дансны мэдээлэл.....	7
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар.....	8
10. Гол, онцлог гүйлгээний талаар.....	8
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар.....	10
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар.....	14
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	14
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	14
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	14
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
17. Аудитын гэрчилгээний талаар санал дүгнэлт.....	15

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Татварын ерөнхий газрын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /САГ/2016/12/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2015 оны 3 дугаар сарын 05-наас 2015 оны 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын Нэгтгэсэн тайлангийн аудитын алба /НТАА/-ны аудитор П.Чанцалдулам, шинжээч Д.Будмаа нар хэрэгжүүлэв.

Татварын ерөнхий газар 2015 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг 2016 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 11/504 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388, 2008 оны 352 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, “Эдийн

засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалаар Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн дэлгэрэнгүй ангилал, Төсвийн эх үүсвэрийн ангилал, Төсвийн бусад мэдээллийн болон Балансын дансны ангиллыг 4-5 дугаар хавсралт, “Тушаалд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 55 дугаар тушаалаар Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар, “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”-ыг ашиглаж байна.

Харин тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хуулиудын нэг болох Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр өөрчлөлт оруулсан мөн “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 341 дүгээр тушаалаар Сангийн сайдын 2006 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 32 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус бүр дагаж мөрдөхөөр заасан байна.

Мөн “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар “Эдийн засгийн ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, “Төсвийн зарим анхдагч ангилал батлах тухай” Сангийн сайдын 2014 оны 150 дугаар тушаалын 1, 2, 3 дугаар хавсралтыг тус тус хүчингүйд тооцсон байна.

Түүнчлэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой Татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулахаар Засгийн газрын тогтоол, Сангийн сайдын тушаал, Татварын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Аудитын явцад төсвийн төвлөрүүлэн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг Татварын ерөнхий газар болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд Үндэсний татварын албаны эрхэм зорилго орших ба төрийн үйлчилгээг жигд, чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэх, ил тод, мэргэшсэн байх, хууль ёсыг сахих, үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээх үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна.

Үндэсний татварын албаны чиг үүрэг нь:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т заасны дагуу Татварын ерөнхий газрын дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Гүйцэтгэлийн шатанд санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 9 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аудитын нарийвчилсан горим, сорилыг хэрэгжүүлэх явцад гарсан зарим онцлог ажил гүйлгээнээс дурдвал дараах байдалтай байна.

- Засгийн газрын 2015 оны 389 дүгээр тогтоолоор “Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, тайлбарлах ажил”-д шаардагдах нийт 350.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсврийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлсэн байна. Үүнээс Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэхэд 246.0 сая, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг тайлбарлах ажилд 104.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.
- Улсын төсвийн орлого хяналтын газрын батлагдсан орон тоо 86 бөгөөд тайлант онд ажиллагсаддаа сар бүр үндсэн цалингийн 25 хувиар тооцож, үр дүнгийн урамшуулалд нийт 110.0 сая төгрөгийг олгосон байна.

Тав. Материаллаг байдлыг тодорхойлох

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож 783.5 сая төгрөгөөр тогтоосон болно. /ТАБ-СТА-В-1/

Татварын ерөнхий газрын даргын 2013 оны 104 дүгээр тушаалаар баталсан “Үндэсний татварын албаны Нягтлан бодох бүртгэлийн бодлого, горим”-ыг мөрдөн ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан, түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “дунд” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнгийн оролцоо шаардагдах магадлалтай гэсэн үнэлгээ гарсан ба аудитыг хийж гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тайлант хугацаанд Татварын ерөнхий газрын УТОХГ, ТЕГ-ын аппарат, аймаг, нийслэл, дүүргийн татварын хэлтсүүд санхүүгийн бүртгэлээ Интер-Актив ХХК-ийн санхүүгийн “Emerald”, цалингийн “Payroll” програмаар тус тус хөтөлж, санхүүгийн тайланг гаргасан. Харин системийн санхүүгийн нэгтгэсэн тайланг санхүүгийн тооцоолох компаний “Plastic” програмаар нэгтгэн гаргасан байна.

Зургаа. Дотоод хяналтын талаар

ТЕГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /ХШҮДАГ/ нь 2015 онд газрын дарга, татварын улсын ахлах байцаагч 1, татварын улсын байцаагч 4 нийт 6 орон тоотой /*үүнээс санхүүгийн дотоод аудитыг 2 байцаагч хавсран гүйцэтгэсэн*/ үйл ажиллагаагаа явуулж иржээ.

ХШҮДАГ-ын 2015 оны зорилт: Дээд газрын бодлого, зорилт, хөтөлбөр, тогтоол шийдвэр, “Үндэсний татварын алба /ҮТА/-ны 2014-2016 оны хөгжлийн зорилтот хөтөлбөр”, “ҮТА-ны 2015 оны үндсэн чиглэл”, “Бизнес эрхлэлтийг дэмжих жил” дэвшүүлсэн зорилт болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээнүүд нь үр дүнд хүрсэн эсэхийг нягтлан тогтоох, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажил нь үр дүнд хүрч хэрэгжээгүй бол түүнийг засаж, залруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан удирдлагыг шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх мэдээлэл, зөвлөмжөөр хангахад чиглэгдсэн байна.

Дээрх зорилтыг ханган ажиллахын тулд тайлант онд дараах шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийжээ Үүнд:

- Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ
- Зорилтын хэрэгжилтийн зохицуулалтын үнэлгээ
- Байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ
- Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ
- Чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

ТЕГ-ын дотоод бүтэц нэгжийн 2015 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүн, тайланд үндэслэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж,

үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр нийт 19 зөвлөмж өгч, ТЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТЕГ-ын даргын тушаалаар үүрэг чиглэл өгч ажилласан байна.

ТЕГ-ын ХШҮДАГ-аас 2015 онд санхүүгийн үйл ажиллагаанд тухайлсан аудитын шалгалт хийж, зөвлөмж өгөөгүй боловч байгууллагын дотоод бүтэц нэгжүүдийн сар бүрийн төлөвлөгөөт ажлын биелэлтэд үнэлгээ хийж, дүнг нэгтгэн удирдлагыг мэдээллээр ханган ажилласан байна.

Мөн ХШҮДАГ-аас ТЕГ-т аудит, хяналт-шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэн 88.7 хувь буюу “В” үнэлгээтэй дүгнэсэн байна.

Зөвлөмж өгсөн байгууллага	Зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын хэрэгжилт	
	тоо	Хувь
Үндэсний аудитын газар	5	88.0
Сангийн яам	5	90.0

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад системийн хэмжээнд үнэт цаас, тооцоот маягтын бүртгэл, тайлагнал, түүний зарцуулалтанд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаар

Татварын ерөнхий газрын системийн хэмжээнд 2015 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу харьяа газар, хэлтсүүдэд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулан, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангаж, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Үндэсний татварын алба нь 2015 онд 34 татварын алба, 1,823 ажиллагсадтайгаар, Сангийн сайдын багцад УИХ-аас баталж өгсөн төсвийн хүрээнд улсын төсвөөс урсгал зардлын санхүүжилтэд 27,735.6 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжих 3,576.0 сая, бүгд 31,311.6 сая төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулсан байна.

Орон тооны бус татварын байцаагчдын цалин, урамшилд зориулан 2,944.4 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн төсвөөс авсан байна. Мөн төсвийн дээд шатны захирагчийн хөрөнгөөс хуваарилсан төсвийн хөрөнгөөр 345.1 сая төгрөгийн төсвийг нэмж олгосон байна.

Татварын албад нь туслах үйл ажиллагааны болон маягт, үнэт цаасны орлогоор 2,492.0 сая, түрээсийн орлогоор 13.2 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 1,096.5 сая, урсгал санхүүжилт 29,424.8 сая, нэмэлт санхүүжилтийн орлого 3,397.9 сая, бусад орлогоор 13.1 сая төгрөгийг тус тус олж нийт 36,437.5 сая төгрөгийн орлоготойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Найм. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан эсэх, хуулийн хэрэгжилтийн явцтай танилцахад:

Үндэсний татварын алба нь 34 татварын албадтай бөгөөд тус бүр shilendans.gov.mn цахим хуудсанд нэвтрэх эрхийг нээлгэн "Шилэн дансны тухай" хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журамд заасны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.Үүнд:

1. Өөрийн www.mta.mn цахим хуудсанд шилэн дансны бие даасан цэсийг ажиллуулж байна. Тухайлбал:
 - Шилэн данс цэс нь shilendans.gov.mn хуудсанд шууд нэвтрэх байдлаар;
 - Ил тод байдал цэс нь байгууллагын цахим хуудсанд шилэн дансны мэдээллийг иргэд шууд харж танилцах, мэдээллийг татаж авах, хэвлэх боломжтойгоор байршуулсан;
2. Татварын ерөнхий газар, Нийслэлийн татварын газар, Улсын төсвийн орлого хяналтын газар, аймаг, дүүргийн татварын газар, хэлтэс тус бүр шилэн дансны мэдээллийн самбарыг ажиллуулж, иргэдийг мэдээллээр хангах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна;
3. "Шилэн дансны тухай" хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай" журамд заасны дагуу:
 - 2014 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, ТЕЗ-ын төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлт, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга
 - 2015 оны хагас жилийн санхүүгийн тайлан
 - 2015 оны тодотгосон төсвийн хуваарь
 - 2015 оны төсвийн орлогын төлөвлөгөө
 - 2016 оны төсвийн төсөл
 - 1-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэл
 - 1-12 дугаар сарын татварын орлогын биелэлт
 - 5 сая төгрөгөөс дээш 77.2 сая төгрөгийн 2 орлогын гүйлгээ, 586.2 сая төгрөгийн 20 зарлагын гүйлгээ
 - Тендер, худалдан авалттай холбоотой 2 мэдээлэл

- Таван сая төгрөгөөс дээш 110.1 сая үнийн дүн бүхий 3 худалдан авалтын мэдээллийг shilendans.gov.mn цахим хуудсанд болон байгууллагын www.mta.mn цахим хуудсанд байршуулжээ.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 9 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаар

Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүн бүхий дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-З/

Засгийн газрын 2014 оны 285 дугаар тогтоолоор Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулж, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газрын даргад даалгаж, төслийн нэгжийн үйл ажиллагаанд нэн тэргүүн шаардлагатай 2014 оны санхүүжилтийн зардлыг Сангийн сайдын төсвийн багцаас гаргаж, бусад зардлыг 2015 оны төсөвт суулгаж, санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна.

Мөн Сангийн сайдын 2014 оны “Төслийн нэгж байгуулж, хөрөнгө гаргах тухай” 225 дугаар тушаалыг үндэслэн ТЕГ-ын даргын 2014 оны А/392 дугаар тушаалаар төслийн нэгжийг байгуулж, А/464 дүгээр тушаалаар төслийн нэгжийн бүтэц, орон тоог 40 ажилтантай байхаар баталж, тус байгууллагын даргын А/482 дугаар тушаалаар төслийн ажилтнуудын сарын цалингийн хэмжээг тогтоохдоо Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6.4, 27.6.10 дахь заалтууд болон “Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх” төслийн техник эдийн засгийн үндэслэлийн 1.9.5.1-т үндэслэн 1,220,000-4,550,000 төгрөгийн хооронд тогтоожээ.

2015 онд ТЕГ-ын Орон нутгийн хуваарилагдаагүй зардлын дансны мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд нийт 1,967.4 сая төгрөг батлагдсанаас 1,627.3 сая төгрөг нь Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийн санхүүжилтийн зардал байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийн санхүүжилтийн зарцуулалт гүйцэтгэлээр 1,626.8 сая төгрөг бөгөөд мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас дараах онцлог ажил гүйлгээнүүд хийгдсэн байна. Тухайлбал:

- Цалинд -1,061.7 сая,
- Нийгмийн даатгалын шимтгэлд-184.4 сая,
- Хувь хүний орлогын албан татварт-113.4 сая,

- Шатахуунд-1.2 сая,
- Томилолтод-56.0 сая,
- Бичиг хэргийн материалд-5.3 сая,
- Хөрөнгө бэлтгэхэд-121.4 сая,
- Зочин хүлээн авахад-4.0 сая,
- Мэдээлэл сурталчилгаанд-79.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Татварын ерөнхий газрын аппаратын 2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараагийн аудитаар авч үзэх асуудлаар тусгасан Татварын ерөнхий газар, харъяа газар хэлтсүүдтэй үнэт цаас, тооцоот маягтын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулсан бүртгэл, тайлагнал, болон тооцоот маягтын орлогын бүртгэлтэй аудитын явцад танилцахад ТЕГ-аас харъяа газар хэлтсүүдэд олгосон нийт тооцоот маягт 2,382,857 ширхэг буюу 106.2 сая төгрөг ба газар хэлтсүүдээс төвлөрүүлэн бүртгэсэн тооцоот маягтын орлого 154.7 сая төгрөг байна.

Харин ТЕГ-ын харъяа газар хэлтсүүд үнэт цаас, тооцоот маягтын орлогыг харилцан адилгүй бүртгэлд тусгаж, тайлагнажээ. Тухайлбал: / үнэт цаас, тооцоот маягтын орлогыг 7 байгууллага ТЕГ-ын төрийн сангийн орлогын дансанд, 3 байгууллага өөрийн байгууллагын урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 7 байгууллага нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд, 2 байгууллага арилжааны банкин дахь дансанд, 13 байгууллага кассаар / дамжуулан тухайн сарын орлогыг Төрийн сан дахь ТЕГ-ын орлогын дансанд төвлөрүүлж, санхүүгийн тайландаа зарим байгууллага нь орлогоор тайлагнаж, зарим нь орлогыг цэвэрлэн толилуулсан байна.

ТЕГ-ын харъяа газар, хэлтсүүд нь үнэт цаас, тооцоот маягтын орлогыг НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аккурэл сууриар бүртгэж, тайлагнаагүйгээс тайлант онд нийт 154.7 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд уг орлогыг тохируулах, устгалтын бичилт хийгдээгүй байна.

ТЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Өмнөговь, Булган, Дархан, Дундговь, Орхон, Төв аймгууд, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх дүүргүүдийн Татварын хэлтсүүдийн аудитлагдсан санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлүүд нь өмнөх оны аудитлагдсан санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлүүдтэй зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Аудитын явцад Татварын ерөнхий газрын хэмжээнд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн.

Санхүүгийн тайлан гаргалтын талаар:

Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 33 хэлтэс, газрын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн бөгөөд нийт төсвийн багцын 32.0 хувь буюу Улсын төсвийн орлого хяналтын газар, Орон нутгийн хуваарилагдаагүй зардлын дансыг түүвэрт хамруулан, ТЕГ-ын аппаратын санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар, 31.0 хувьд нь Нийслэлийн аудитын газар, 37.0 хувьд нь аймгийн аудитын газар аудит хийж дүгнэлт өгсөн болно.

2015 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 32 газар хэлтсүүдийн тайланд “зөрчилгүй”, Татварын ерөнхий газрын аппаратын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн бол 2014 оны санхүүгийн тайлангийн аудитаар Баянзүрх, Хан-Уул дүүрэг, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн санхүүгийн тайланд “хязгаарлалттай”, бусад газар хэлтсүүдийн санхүүгийн тайланд “зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Сэлэнгэ, Дорнод аймгуудын аудитын газар нь тус аймаг дахь Татварын хэлтсүүдийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн гэж итгэл үзүүлэн, аудитад хамруулах шаардлагагүй талаар тус аймгуудын аудитын газруудын 2016 оны 22 болон 42 дугаар албан бичгээр мэдэгдсэн байна.

Төсвийн шууд захирагчдын 2015 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар нийт 3,437.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 3.0 сая төгрөгийн зөрчилд 4 акт тавигдсан, 17.6 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага бичигдсэн, 3,207.4 сая төгрөгийн зөрчилд 68 зөвлөмж өгөгдсөн, 209.1 сая төгрөгийн 21 алдаанд залруулга хийгдсэн байна.

Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг УСНББОУС-ын 6 дахь заалтын дагуу мөр бүрээр нэгтгэх зарчмыг баримтлан төсвийн шууд захирагчдын аудитлагдсан санхүүгийн тайланг нэгтгэн толилуулсан байна.

Авлага, өглөгийн дансны талаар:

ТЕГ-аас авсан судалгаагаар тус байгууллагын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлагнагдсан авлагын үлдэгдэл 2,170.2 сая, өглөгийн үлдэгдэл 166.8 сая төгрөг ба өмнөх оны мөн үеэс авлага 26.7 хувь буюу 791.0 сая, өглөг 12.4 хувь буюу 23.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Нийт авлагын үлдэгдлийн 94.0 хувь буюу 2,043.8 сая, өглөгийн үлдэгдлийн 56.0 хувь буюу 94.2 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн 93.0 хувь буюу 2,011.4 сая төгрөг нь ТЕГ-ын аппаратын авлагын үлдэгдэл байгаа бол өглөгийн үлдэгдлийн 34 хувь буюу 56.9 сая төгрөг нь ТЕГ-ын аппарат, 28 хувь буюу 46.6 сая төгрөг нь Баянзүрх дүүргийн татварын хэлтэс, 12 хувь буюу 19.8 сая төгрөг нь Нийслэлийн татварын газрын өглөгийн үлдэгдлүүд байна.

ТЕГ-ын аппаратын 2,011.4 сая төгрөгийн авлагын үлдэгдлийн 1,997.1 сая төгрөг нь Сангийн яамнаас авах авлага бөгөөд үүний 1,747.9 сая төгрөг нь 2013 онд үүссэн бол 249.2 сая төгрөгийг тайлант онд нэмж бүртгэн Сангийн яамтай тооцоо нийлж, баталгаажуулжээ.

Судалгаанаас харахад санхүүгийн тайланд тайлагнагдсан нийт авлагын үлдэгдлийн 0.3 хувь буюу 7.6 сая, өглөгийн үлдэгдлийн 19 хувь буюу 31.1 сая төгрөг нь 5-с дээш жил болсон авлага, өр төлбөр байгааг ТЕГ-ын удирдлагын анхааралд хандуулж, 2016 онд уг асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг зөвлөж байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитад түүврээр хамрагдсан дансдын харилцах болон кассын тайлангийн ажил гүйлгээнээс түүвэрлэн шалгахад Улсын төсвийн орлого хяналтын газрын болон Орон нутгийн хуваарилагдаагүй зардлын данснаас нийт 7.3 сая төгрөгийг баримтын бүрдэл дутуу зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн Иж бүрэн байх-д “аж ахуй нэгж байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, гэж заасныг мөрдөн ажиллаж, анхан шатны баримтгүйгээр мөнгөн хөрөнгийн зарцуулалт гаргахыг таслан зогсоож ажиллахыг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

2. Тайлант онд мэдээлэл технологийн үйлчилгээний зардлаас Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийн үйл ажиллагааны санхүүжилтэд нийт 1,626.8 сая төгрөгийг зарцуулахдаа дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- Цалинд -1,061.7 сая,
- Нийгмийн даатгалын шимтгэлд-184.4 сая,
- Хувь хүний орлогын албан татварт-113.4 сая,
- Шатахуунд-1.2 сая,
- Томилолтод-56.0 сая,
- Бичиг хэргийн материалд-5.3 сая,
- Хөрөнгө бэлтгэхэд-121.4 сая,
- Зочин хүлээн авахад-4.0 сая,
- Мэдээлэл сурталчилгаанд-79.3 сая төгрөг байна.

Энэ нь АОУС-250 “Санхүүгийн тайлангийн аудитад хууль тогтоомж, дүрэм журмыг анхаарах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан “Төсвийн орлогын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, Төсвийн зарлагын хөтөлбөрийн ангилал, Зардлын зориулалт, арга хэмжээний ангилал”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан журамтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төслийн үйл ажиллагааны төсвийг тухайн жилийн өөрийн үйл ажиллагааны санхүүжүүлтээс тусад нь батлуулж, холбогдох зарцуулалтыг зардлын эдийн засгийн ангиллаар нь бүртгэлд тусгаж, тайлагнаж байхыг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

3. Санхүүгийн бүртгэл, тайлагналтай холбоотой дараах бүртгэлийн алдаа ТЕГ-ын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн.Тухайлбал:

- ТЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн тайлант оны элэгдлийн зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн элэгдлийн зардал 34.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг аудитын явцад залруулсан;
- ТЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн уялдааг шалгахад санхүүгийн байдлын болон өмчийн өөрчлөлтийн тайланд тайлагнагдсан тайлант оны үр дүн (2,976.5) сая төгрөг бол санхүүгийн үр дүнгийн тайлангийн устгалтын дараах тайлант оны үр дүн (3,016.5) сая төгрөгөөр бүртгэгдэж, нийт 40.0 сая төгрөгөөр зөрсөн нь газар, хэлтсүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний устгалтын бичилтийг буруу хийснээс үүссэн ба уг алдааг аудитын явцад залруулсан;
- ТЕГ-ын харъяа газар, хэлтсүүд нь үнэт цаас, тооцоот маягтын орлогыг НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу аккурэл сууриар бүртгэж, тайлагнаагүйгээс тайлант онд нийт 154.7 сая төгрөгийн орлогыг мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрч бүртгээгүй, төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд уг орлогыг тохируулах, устгалтын бичилт хийгдээгүй байна.
- ТЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Өмнөговь, Булган, Дархан, Дундговь, Орхон, Төв аймгууд, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Налайх дүүргүүдийн Татварын хэлтсүүдийн аудитлагдсан

санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлүүд нь санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн эхний үлдэгдлүүдтэй зөрүүтэй нэгтгэгдсэн байна.

Эдгээр нь АОУС 510 зорилго 3 (а)-д “Өнөө үеийн санхүүгийн тайлангуудад материаллагаар нөлөөлж болох алдаатай тайлагналуудыг эхний үлдэгдлүүд агуулж буй эсэх; мөн”, аудитын горимууд 2 (а)-д “Өмнөх үеийн эцсийн үлдэгдлүүдийг зохистойгоор өнөө үед шилжүүлэн тусгасан эсэх, эсвэл тохиромжтой бол дахин тайлагнасан эсэхийг тодорхойлох”, (в)-1.т “Өмнөх жилийн санхүүгийн тайлангууд аудитлагдсан бол эхний үлдэгдлүүдийн талаар нотолгоо олж авахын тулд өмнөх аудиторын ажлын баримтыг нягтлан шалгах”, (в)-3.т “Өнөө үед гүйцэтгэж буй аудитын горимууд нь эхний үлдэгдэлтэй холбогдох нотолгоог бүрдүүлж буй эсэхийг үнэлэх”, АДБОУС-1230 “Гүйцэтгэсэн аудитын горим, олж авсан аудитын нотлох зүйлсийн баримтжуулалт”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, аудитын батламж мэдэгдлийн *Иж бүрэн байх*-д “Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх”, аудитын батламж мэдэгдлийн *Оршин байх*-д “санхүүгийн тайлангийн дуусгавар болсон өдөр хөрөнгө /авлага/, өр төлбөр тухайн аж ахуйн нэгж, байгууллагад бодитой оршин байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: УСНББОУС-ын дагуу ажил гүйлгээг аккурэл сууриар үнэн зөв бүртгэлд тусгаж, санхүүгийн тайланг толилуулах ба бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

4. Төсвийн шууд захирагчдын 2015 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитаар нийт 3,437.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 3.0 сая төгрөгийн зөрчилд 4 акт тавигдсан, 17.6 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага бичигдсэн, 3,207.4 сая төгрөгийн зөрчилд 68 зөвлөмж өгч, 209.1 сая төгрөгийн 21 алдаанд залруулга хийгдсэн байна.

Мөн ТЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн нийт 35 төсвийн шууд захирагчдаас Хөвсгөл, Дорнод, Дорноговь, Ховд, Увс, Өвөрхангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Завхан аймгуудын татварын хэлтсүүд болон түүврээр хамрагдсан Орон нутгийн хуваарилагдаагүй зардлын данс, Улсын төсвийн орлого хяналтын газруудын мөнгөн гүйлгээ болон үр дүнгийн тайлангийн өмнөх оны дүн татагдаагүй нэгтгэгдсэн нь аудитлагдсан тайлангийн өмнөх оны үлдэгдлийг тулган баталгаажуулах боломжгүйд хүргэсэн.

Энэ нь АОУС 510 зорилго 3 (а)-д “Өнөө үеийн санхүүгийн тайлангуудад материаллагаар нөлөөлж болох алдаатай тайлагналуудыг эхний үлдэгдлүүд агуулж буй эсэх; мөн”, аудитын горимууд 2 (а)-д “Өмнөх үеийн эцсийн үлдэгдлүүдийг зохистойгоор өнөө үед шилжүүлэн тусгасан эсэх, эсвэл тохиромжтой бол дахин тайлагнасан эсэхийг тодорхойлох”, (в)-3.т “Өнөө үед гүйцэтгэж буй аудитын горимууд нь эхний үлдэгдэлтэй холбогдох нотолгоог бүрдүүлж буй эсэхийг үнэлэх”, АДБОУС-1230 “Гүйцэтгэсэн аудитын горим, олж

авсан аудитын нотлох зүйлсийн баримтжуулалт”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-д “Бүртгэл, тайлангийн тоо, мэдээг аргачлалын хувьд өнгөрсөн, ирээдүйн тоо, мэдээтэй зэрэгцүүлж болохоор зохиох”, аудитын батламж мэдэгдлийн Иж бүрэн байх-д “Аж ахуйн нэгж, байгууллага тайлант хугацаанд гарсан бүх ажил гүйлгээ, үлдэгдэл буюу үйл явдал, нөхцөл байдлуудаас бүртгээгүй, нэмж тодруулаагүй, орхигдуулсан зүйлсгүй байх” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод аудитын дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1-д "Төсвийн захирагчийн дотоод аудитын үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино", мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Дотоод аудитын нэгж нь Төрийн аудитын байгууллагатай дараахь хүрээнд хамтран ажиллаж болно 9.1.1-9.1.3 дахь заалт" гэснийг тус тус мөрдөж, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар нь хөндлөнгийн хараат бус аудитын шалгалтаар илэрсэн дээрх асуудлуудад анхаарал хандуулан ажиллаж, шалгалтын үр дүн, бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулах талаар ТЕГ-ын удирдлагад зөвлөмж болгох;

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Арван дөрөв. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2014 оны Засгийн газрын 285 дугаар тогтоол, Сангийн сайдын “Төслийн нэгж байгуулж, хөрөнгө гаргах тухай” 225 дугаар тушаалд тус тус үндэслэн ТЕГ-ын даргын 2014 оны А/392 дугаар тушаалаар Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулж, А/464 дүгээр тушаалаар төслийн нэгжийн бүтэц, орон тоог 40 ажилтантай байхаар баталж, тус байгууллагын даргын А/482 дугаар тушаалаар төслийн ажилтнуудын сарын цалингийн хэмжээг 1,220,000-4,550,000 төгрөгийн хооронд тогтоосон байгаад нийцэлийн аудит хийлгэх нь зүйтэй гэж үзэж байна.

Арван тав. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Татварын ерөнхий газрын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,863.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс аудитын

явцад 74.7 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.15 сая төгрөгний акт тавигдаж, 1,626.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдэж, 163.6 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Татварын ерөнхий газрын удирдлагын анхааралд хандуулж 4 зөвлөмж өгсөн.

Арван зургаа. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Үндэсний аудитын газар болон нийслэл, орон нутгийн аудитын байгууллагаас Татварын ерөнхий газрын төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 777.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 67 зөвлөмж өгч, 376.5 сая төгрөгийн зөрчилд 22 албан шаардлага хүргүүлж, 11.6 сая төгрөгийг төсвийн орлого болгохоор 19 акт тогтоосон /*үүнээс ТЕГ-ын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар 5 зөвлөмж өгсөн*/ байна.

ТЕГ-ын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 89.0 хувийн биелэлттэй байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 12/1945 дугаар албан бичгийн хамт Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Арван долоо. Зөрчилгүй санал дүгнэлт

Татварын ерөнхий газрын даргын төсвийн багцын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын тайланд хавсралт тайлан /9 хуудас/-ыг хавсаргав.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2016 оны 3 дугаар сар



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

УАГ-ын Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: С.Энхзаяа
Утас: 261663
Цахимхаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Аудитор: П.Чанцалдулам
Шинжээч: Д.Будмаа
Утас: 261740
Цахимхаяг:
chantsaldulamp@audit.gov.mn
budmaad@audit.gov.mn

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар

Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3
Засгийн газрын IY байр
Улаанбаатар хот 15160
Монгол Улс

Цахим хуудас: www.audit.mn

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар хуудас 3

Асуудал 2

Төсөвт зардлын талаар хуудас 4

Асуудал 3

Бүртгэл тайлагналын талаар хуудас 5

Асуудал 4

